



АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн /ДОА-2019/40-ГА/



"ДБЭХС" ТӨХК



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ХУУЛЬ, ЖУРМЫГ БҮРЭН МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Чойбалсан хот

2019 он

**Агуулга**

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа,

Аудитор
Я.Зориг
С.Энхбаатар
Утас: 70584207

2019 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207, 70584204
дугаарын утас болон
dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,
2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**I Бүлэг. Худалдан авах ажиллагааг зохион
байгуулахдаа хууль, журмыг бүрэн мөрдөж
ажиллаагүй байна.**

1.1. ТБОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагааны
төлөвлөлт хангалтгүй байна.

1.2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд
ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д заасан төлөөллийг
бүрэн оруулаагүй байна.

1.3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа
хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

**II Бүлэг. Худалдан авах ажиллагаанд тавих хяналтыг
сайжруулах шаардлагатай байна.**

2.1. Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн
өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг бүрэн тооцсон
байна.

2.2. Тайлант хугацаан дахь худалдан авалтаар бий
болсон хөрөнгийн ашиглалт хангалттай байна.

2.3. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтыг
төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ
ЗӨВЛӨМЖ
ТУШААЛ
АЛБАН ШААРДЛАГА



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГА	Гүйцэтгэлийн аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НАА	Нийтийн аж ахуй

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг МҮЕА-ын орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүнд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулсан эсэх,
- Худалдан авах ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн төрийн болон орон нутгийн өмчит компаниудын 2018 он, 2019 оны эхний улирлын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авалт, дотоод болон хөндлөнгийн хяналт, тендерийн баримт бичиг, холбогдох гэрээ, баримт, бусад холбогдох материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

“Дорнод НАА” ОНӨААТҮГ нь 2018 онд 124.3 сая төгрөгөөр 7, 2019 онд 217.2 сая төгрөгөөр 18 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг төлөвлөн баталсан байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2018 онд 9592.1 сая төгрөгийн 113, 2019 онд 10057.7 сая төгрөгийн 114 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ нь 2018 онд 163.0 сая төгрөгийн 5 бараа, ажил, үйлчилгээ, 2019 онд 110.0 сая төгрөгийн 3 бараа, ажлын худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ нь 2018 онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй, 2019 онд 30.0 сая төгрөгөөр 1 ажил худалдан авахаар төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

**Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль /15.2.2, 23.1/
- Төсвийн тухай хууль /5.1.1-5.1.5, 24.4, 25.1, 28.6, 29, 41, 69/
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /6, 74-81/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /4, 6, 8-13, 16-58/
- Холбогдох бусад хууль, журам, хууль эрхийн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа удирдан, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлэн тайланг 06 дугаар сарын 25-ны өдөр дуусган Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.



I Бүлэг. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

1.1. ТБОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” болон холбогдох бусад эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

Худалдан авах ажиллагааг дээрх хууль, журмын дагуу төлөвлөсөн эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.

“ДБЭХС” ТӨХК:

Жил бүрийн үйл ажиллагаандаа худалдан авах бараа, ажил үйлчилгээг төлөвлөж, ТУЗ-ийн хуралд оруулж, хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас баталсан жилийн зорилтот түвшний үзүүлэлтэд тусгадаг байна. 2018 онд их засварын ажилд 2.5 тэрбум, техник, зохион байгуулалтын арга хэмжээгээр хийгдэх ажилд 1.8 тэрбум, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд 2.5 тэрбум, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бараа материал, бусад үйлчилгээ худалдан авахаар 2.8 тэрбум, нэмэлт тодотголоор 3.6 тэрбум, нийт 13.2 тэрбум, 2019 онд 10.1 тэрбум төгрөгийн 128 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, батлуулсан байна.

Хөрөнгө оруулалт, засвар, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний төслийг 2018, 2019 онд боловсруулахдаа хэлтэс, тасаг, цех, нэгжүүдэд зайлшгүй шаардагдах бараа, ажил, үйлчилгээний саналуудыг, тооцоо судалгааны хамт захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2018 оны төлөвлөгөөнд тусгаагүй 192.1 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт:1. “Төлөвлөгөөнд тусгаагдаагүй ажлууд”

№	Төсөл төсөл, хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэсэн байгууллага
1	Камаз краны туслах кроп	15.0	“Дээд ураг” ХХК
2	Холбооны гар станц	9.8	“Тэнүүн импекс” ХХК
3	ТС-1 шатахуун	16.7	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудал
4	Мембрани элемент	48.0	“Икс Икс И Эм” ХХК
5	ПАЭС-2500	48.0	“Ситтингс” ХХК
6	Мембрани элемент	48.0	“Икс Икс И Эм” ХХК
7	Хөргөлтийн төхөөрөмж	6.6	“Хөргөлт сервис” ХХК
	Нийт	192.1	



Өвөлжилтийн хүндрэлтэй цех, тасгуудад бэлтгэл ажил хангахтай холбогдуулан зайлшгүй шаардлагаар нөөц бүрдүүлэх зорилгоор дээрх ажилд шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь төлөвлөлтийн шатны тооцоо, судалгаа дутуу хийгдсэнтэй холбоотой байна.

Мөн www.shilendans.gov.mn сайтад тавигдсан “ДБЭХС” ТӨХК-ийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан төлөвлөгөөнөөс зөрүүтэйгээр нийтэлсэн нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.9¹ дэх заалтыг баримтлаагүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

Худалдан авалтыг төлөвлөхдөө тасаг, нэгжүүдээс шаардлагатай болон эвдрэл гэмтэлтэй байгаа хөрөнгийн саналуудыг авч нэгтгэн эрэмбэлэн гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн худалдан авалтын төлөвлөгөөний төслийг ТУЗ-ийн хурлаар оруулж батлуулсан байна. 2018 онд 7, 2019 онд 18 төсөл арга хэмжээг төлөвлөж хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

Тус газар нь 2018 онд 143.0 сая төгрөгийн өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүнээс 5.0 сая төгрөгийн өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ нь аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдөөс гарсан санал, 2019 онд 108.0 сая төгрөгийн өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүнээс 37.5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ нь ИТХ-ын төлөөлөгчдөөс гарсан санал байна.

Бусад 163.5 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг өөрсдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан төлөвлөсөн гэх боловч, дотоод хурлаар хэлэлцүүлж, эрэмбэлж, санал авсан тухай баримт байхгүй, үр дүнгийн талаарх тооцоо судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

Тус газар нь 2018 онд 10.0 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийгдээгүй, 2019 онд Хэрлэн сумын 5-р багийн хур хогийн цэвэрлэгээ, хог зайлуулах зардалд 30.0 сая төгрөгийг зарцуулах ажлыг аймгийн орон нутгийн төсөвт тусган батлуулж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж баталсан боловч, үр дүнгийн талаарх тооцоо судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

“ДБЭХС” ТӨХК, “Дорнод НАА”, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ууд нь жил бүрийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж ажилласан бол “Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ нь төлөвлөлт хангалтгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.1², 48.5³ дахь заалтуудыг баримтлаагүй байна.

¹ 2.9. Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсанаас хойш 3 хоногийн дотор Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д оруулж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, батлуулна.

² 48.1. Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

³ 48.5. Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

**1.2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д заасан төлөөллийг бүрэн оруулаагүй байна.**

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэж заажээ.

Аудитын явцад аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газрууд нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороодыг хууль, журмын дагуу байгуулсан эсэхийг үзлээ.

“ДБЭХС” ТӨХК:

Тус компани нь өөрийн хөрөнгөөр 2018, 2019 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хуульд заасны дагуу 82 тендерийн үнэлгээний хороодыг нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээтэй байна.

Харин үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн компаниас 3, хувийн хэвшлээс 1, орон нутаг дахь ИТХ-аас 1, иргэдээс 1 төлөөллийг оруулсан байна.

Гэтэл бүх үнэлгээний хороонд орон нутаг дахь Засаг даргын Тамгын газрын төлөөллийг огт оруулаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ..., Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд үнэлгээний хороонд орон нутаг дахь Засаг даргын Тамгын газрын төлөөллийг оруулж байх шаардлагатай байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

Тус ОНӨААТҮГ-т өөрийн болон төсвийн хөрөнгөөр 2018 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулах, тендерийн үнэлгээний хороо байгуулах шаардлага гараагүй байна.

Харин тус ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа тендерийн үнэлгээний хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон 5 гишүүнээс 2 нь худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд мэргэшээгүй байгаа нь хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

Мөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрийн байгууллагын албан хаагчдаас бусад салбарын төлөөллийг огт оруулаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэж заасныг зөрчсөн байна. Энэ нь тухайн байгууллага өөрийн боловсон хүчнээ худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл холбогдох салбарын сургалтад



хамруулж мэргэшүүлэх тал дээр дутмаг, идэвхгүй ажиллаж байгаатай холбоотой байна.

Иймд үнэлгээний хороонд орон нутаг дахь Засаг даргын Тамгын газрын төлөөлөл болон худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан албан хаагчдыг оруулж байх шаардлагатай байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

Тус ОНӨААТҮГ нь 2018 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнэлгээний хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Захиалагч нь тендерийн үнэлгээний хороог байгуулахдаа хэдэн гишүүнтэй байхыг холбогдох хууль, журмаас тооцож үзэхэд хамгийн багадаа 5 байхаар байна.

Гэтэл тус ОНӨААТҮГ нь 2018 онд тендерийн үнэлгээний хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, үнэлгээний хороонд өөрийн байгууллагын 3 ажилтнаас гадна байвал зохих бусад салбарын төлөөллийг огт оруулаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх хуулийн шалгуурыг хангаагүй албан хаагчийг оруулсан байгаа нь 47 дугаар зүйлийн 47.3-д “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараах шаардлагыг хангасан байвал зохино:”, 47.3.1-д “худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Эдгээр нь тус байгууллагын албан хаагчдаас худалдан авах ажиллагааны чиглэлээр АЗ-ын сургалтад хамрагдсан албан хаагч дутагдалтай байгаатай холбоотой байна.

Иймд үнэлгээний хороонд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д заасан төлөөлөл болон худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан албан хаагчдыг оруулж байх шаардлагатай байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

Тус компани нь 2018 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдаагүй байна. Мөн 2019 оны 1-р улиралд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдаагүй байна. Энэ нь тус байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь хуульд заасан харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас даваагүйтэй холбоотой байна.

1.3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнийн санал авах урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд нийтлүүлж, цахим сайтад байршуулсан байх, дотоодын зах зээлд давуу эрх олгосон эсэх, тендерт оролцогчдыг мэдээллээр хангаж, шалгаруулалтыг ил тод, нээлттэй явуулсан эсэх, босго үнэ, хэрэглэх аргыг зөв сонгосон байх, ААН, компаниудаас гомдол гарсан эсэх, гомдлыг барагдуулсан



байдал, баримт бичгийг зөв үнэлсэн эсэх зэрэг шалгууруудыг хангасан эсэхийг үзлээ.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ нь харьцуулалтын аргаар зохион байгуулагдах 2 ажилд үнийн санал авах урилгыг ААН-үүдэд хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, 7 ажилд тендерийн урилгыг www.tender.gov.mn сайтад байршуулаагүй байна. Харьцуулалтын арга амжилтгүй болсон 93.0 сая төгрөгийн 3 ажилд шууд гэрээ байгуулсан ч, гэрээний хувийг үндэслэлийн хамт Сангийн яаманд хүргүүлээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.3⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Тендер шалгаруулалтын явцын талаар шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс гомдол, санал гараагүй байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ нь 2019 онд 5-р багийн хур хогийг цэвэрлэх ажилд 30.0 сая төгрөгийг батлуулж, тус ажлын тендерийг 2 багц болгон зохион байгуулсан байна.

Нэгдүгээр багц 16.5 сая төгрөгийн ажилд 2 аж ахуйн нэгжээс үнийн санал ирүүлж, “Мянган ургац” ХХК ТББ-ийн иж бүрдэл, ажлын тоо хэмжээг бүрэн тусгасан, гишүүдийн 100 хувийн саналаар шалгарсан байна.

Хоёрдугаар багц 13.5 сая төгрөгийн ажилд 2 аж ахуйн нэгжээс үнийн санал ирүүлж, “Гранд восток монголиа” ХХК-ийн тендерийн баримт бичгийг ерөнхий, тусгай шаардлагыг хангасан гэж үзэн шалгаруулсан байна.

Тендерийн урилгыг 3 ААН-д хүргүүлж, www.tender.gov.mn сайтад байршуулж ажиллан, шалгараагүй ААН-үүдээс гомдол гараагүй байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

Тус газрын худалдан авах ажиллагаанд 2018 онд гүйцэтгэлийн аудит хийгдсэн бөгөөд албан шаардлага, зөвлөмж биелэгдсэн байна. 2019 онд 217.2 сая төгрөгийн өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс эхний улирлын байдлаар 91.7 сая төгрөгийн 3 худалдан авах ажиллагааг зарлаж, шалгаруулсан байна.

Конторын 1 дүгээр давхар болон шатны хонгилын засварын ажлын үнийн санал авах урилгыг 3 ААН-үүдэд хүргүүлсэн гэж хурлын тэмдэглэлд дурдсан боловч баримтаар нотлогдохгүй байна. Үүнээс 2 ААН-ээс үнийн санал ирүүлж, бага үнийн санал, ажлын туршлага, тендерийн баримт бичгийн ийн иж бүрдэл хангасан үндэслэлээр “Талын сүлд” ХХК-ийг шалгаруулсан байна.

Үнийн санал авах урилгыг цахим сайт /www.tender.gov.mn/ болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд нийтлүүлээгүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1⁵, 21.2⁶, 21.4⁷ дэх заалтуудыг баримтлаагүй байна.

⁴ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁵ 6.1.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

⁶ 21.1.Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

⁷ 21.4.Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ.

**“ДБЭХС” ТӨХК:**

“ДБЭХС” ТӨХК нь худалдан авалтын 3 аргыг ашиглаж, нээлттэй тендер шалгаруулалтаар 2018 онд 36, харьцуулалтын аргаар 54, шууд худалдан авалтаар 16 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэл 98.0 хувьтай байна.

Хүснэгт №2. “Ашигласан худалдан авалтын арга” /тэрбум.төг/

Он	Нийт төсөл арга хэмжээ		НТШ		Харьцуулалтын арга		Шууд гэрээ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2017	89	7.5	20	5.6	56	1.8	13	0.1
2018	122	13.0	35	10.7	62	2.2	25	0.1
2019	114	10.2	32	7.4	60	2.7	22	0.1

“ДБЭХС” ТӨХК-ийн 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад орон нутгаас нийт шалгаруулалтын 31.7 хувь буюу 37 ААН, 2019 оны эхний улирлын байдлаар 15.8 хувь буюу 3 ААН тус тус шалгарсан байна. Энэ нь сэлбэг, тоног төхөөрөмж нь орон нутагт байдаггүй, ААН-үүд нь тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүйтэй холбоотой байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 48.5-д заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг www.shilendans.gov.mn сайтад байршуулсан байна. Тендерийн үнийн санал авах урилгыг 2018 онд www.tender.gov.mn сайтад байршуулаагүй 3.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт №3.

№	Бараа, ажил, үйлчилгээ	Төсөвт өртөг	Тайлбар
	2018		
1	Хэрлэн-Булган 35кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинэчлэх	2 896 744 800	Цахим сайтад үнийн санал ирүүлэх урилга байршуулсан тухай баримт байхгүй. Нэмэлтээр сүүлд батлагдсан учраас цахим сайтад байршуулах код аваагүй байна.
2	Ажиллагсдын соёл, спортын төвийн их засвар	687 140 600	
	Нийт	3 583 885 400	

Тендерийн үнийн санал авах урилгыг цахим сайтад байршуулаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1, 21.2, 21.4, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын холбогдох заалтуудыг баримтлаагүй байна. Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 2019 онд ХА-аар зохион байгуулсан тендерт үнийн санал авах урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд нийтлүүлээгүй байгаа нь тендерт оролцогчдыг ил тод, нээлттэй мэдээллээр хангах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн 50.0 сая төгрөгөөс дээш болон 2 ба түүнээс дээш удаа тендерт шалгарсан дараах аж ахуйн нэгжүүд байна.



2019.06.25

**Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан
авах ажиллагааны үр дүн**

Хүснэгт №4 "Шалгарсан аж ахуйн нэгжүүд"

№	Шалгарсан ААН	Шалгар- сан давтамж	Нийт үнийн дүн	ААН-ийн харьяалал
2018 он				
1	МЗЭ ХХК	4	220 820 300.0	Бусад аймаг, хотын
2	МЭЗ ХХК	3	1 241 404 100.0	Бусад аймаг, хотын
3	Рутан ХХК	2	150 904 200.0	Бусад аймаг, хотын
4	Айникс инженеринг ХХК	3	354 646 200.0	Бусад аймаг, хотын
5	Гантесла ХХК	4	211 315 800.0	Бусад аймаг, хотын
6	Электрон тоног төхөөрөмж ХХК	4	118 999 800.0	Бусад аймаг, хотын
7	Хишигт партнерс ХХК	2	67 405 000.0	Бусад аймаг, хотын
8	Дорнын тэнхлэг ХХК	3	83 439 100.0	Дорнод
9	Дээд ураг ХХК	2	78 843 200.0	Дорнод
10	Талын сүлд ХХК	2	232 412 900.0	Дорнод
11	ЦОДММ ХХК	2	106 000 000.0	Дорнод
12	РЭМ ХХК	1	406 957 500.0	Бусад аймаг, хотын
13	Дорнын соёлз уул ХХК	1	633 670 600.0	Бусад аймаг, хотын
14	Дорнын үндэс ХХК	1	98 100 000.0	Бусад аймаг, хотын
15	Техникийн цогц шийдэл ХХК	1	60 288 800.0	Дорнод
16	Их ханас ХХК	2	19 609 400.0	Дорнод
17	Промтех автоматик ХХК	2	378 948 000.0	Бусад аймаг, хотын
18	Ураг цөл ХХК	3	61 200 000.0	Бусад аймаг, хотын
19	Калужский завод энергетического машиностроения	1	420 795 000.0	Бусад улс, орны
20	Өнө тэгш ХХК	2	40 891 000.0	Бусад аймаг, хотын
21	Саруул өргөө констракшн ХХК	1	80 000 000.0	Бусад аймаг, хотын
22	Гантэлмэн ХХК	2	62 558 000.0	Дорнод
23	Гантэлмэн ХХК, Дорнын хишиг ХХК	1	159 323 100.0	Дорнод
24	ОАКС ЭКСПРЕСС МОНГОЛИА ХХК	1	449 000 000.0	Бусад аймаг, хотын
25	Амар-Оршихуй ХХК	1	77 352 000.0	Бусад аймаг, хотын
26	Мэргэдийн өлгий ХХК	1	72 190 000.0	Бусад аймаг, хотын
27	НИК ХХК	1	390 000 000.0	Дорнод
28	Жараахайн булаг	1	250 525 400.0	Дорнод
29	Сод монгол групп ХХК НИК ХХК	1	667 775 700.0	Дорнод
30	Нержфорум ХХК	2	122 038 400.0	Бусад аймаг, хотын
31	Дорнын хишиг ХХК	1	55 817 500.0	Дорнод
32	Вэллд олл ХХК	1	53 062 400.0	Бусад аймаг, хотын
33	Давст оргил ЗГБН	1	51 800 000.0	Бусад аймаг, хотын
34	Уотер голд дриллинг ХХК	2	66 000 000.0	Бусад аймаг, хотын
35	Халиун проперти ХХК	2	36 306 100.0	Бусад аймаг, хотын
36	Монгол даатгал ХХК	3	103 299 000.0	Дорнод
37	Повертүүл ХХК	1	259 307 800.0	Бусад аймаг, хотын
38	Дорнод газар ХХК	1	2 890 018 000.0	Бусад аймаг, хотын
39	Финанс лайн ХХК	1	696 835 001.0	Бусад аймаг, хотын
40	Стандарт материал ХХК	2	64 934 600.0	Бусад аймаг, хотын
				13 Дорнод, 27 Бусад
2019 он				
1	МЭЗ ХХК	4	1 708 425 581.0	Бусад аймаг, хотын
2	Саруул өргөө констракшн ХХК	1	1 200 000 000.0	Бусад аймаг, хотын
3	"ОАКС экспресс монголиа" ХХК	1	77 527 631.0	Бусад аймаг, хотын
4	Ай Вай И Зэт Групп ХХК	2	68 785 000.0	Бусад аймаг, хотын
5	"Топ универсал констракшн" ХХК	1	58 069 365.0	Бусад аймаг, хотын

2018 онд 50.0 сая төгрөгөөс дээш болон 2-оос тендерт шалгарсан аж ахуй нэгжүүдийн 48.0 хувийг орон нутгийн компаниуд, 2019 оны эхний улирлын байдлаар



орон нутгийн компани шалгараагүй байгаа нь дотоодын зах зээлд давуу эрх олгоогүй, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх ААН байхгүйтэй холбоотой байна.

Гэрээ шууд байгуулах төсөвт өртгөөс давсан дараах ажлуудад харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт №5. "Худалдан авалт зохион байгуулаагүй ажил"

№	Төсөл төсөл, хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэсэн байгууллага	ХАА-ны хэрэглэх арга
1	Камаз краны туслах кроп	15.0	"Дээд ураг" ХХК	Харьцуулалт
2	ТС-1 шатахуун	16.7	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудал	Харьцуулалт
3	Мембрани элемент	48.0	"Икс Икс И Эм" ХХК	Харьцуулалт
4	ПАЭС-2500	48.0	"Ситтингс" ХХК	Харьцуулалт
5	Мембрани элемент	48.0	"Икс Икс И Эм" ХХК	Харьцуулалт
	Нийт	175.7		

ТС-1 шатахуун худалдан авах 16.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын хувьд орон нутагт оролцогч байхгүй, нарийн төвөгтэй бараа тул шууд худалдан авалт зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 32.1.1⁸, 34.1.2⁹ дахь заалтыг баримталсан байна.

Камаз краны туслах кроп худалдан авах 15.0 сая төгрөг, мембрани элемент худалдан авах 48.0 сая төгрөг /10-р сард/, ПАЭС-2500 худалдан авах 48.0 сая төгрөг, мембрани элемент худалдан авах 48.0 сая төгрөг /12-р сард/, нийт 159.0 сая төгрөгийн ажилд үнэлгээний хороог хууль, журмын дагуу байгуулаагүй, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан 3-аас дээш аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй, үнийн санал ирүүлсэн тендерийг үнэлэх ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 24.4¹⁰, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.2.1¹¹, 33.2.2¹² дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Харьцуулалт, нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон 2.0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан талаарх үндэслэл, тайланг Эрчим хүчний яаманд хүргүүлсэн боловч, Сангийн яаманд албан бичгээр хүргүүлээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.3¹³ дахь заалтыг зөрчсөн байна.

ХАА-ны явцад Сангийн яаманд 3 удаа, захиалагчид 1 удаа нийт 4 удаа гомдол гарсан байна. Сангийн яамнаас тус гомдлыг хянан үзээд 1 худалдан авалтыг цааш үргэлжлүүлэх, 2 худалдан авалтыг дахин зарлах шийдвэр гаргасны дагуу тендерийг дахин зарлаж, цааш үргэлжлүүлсэн байна. Захиалагчид ирсэн гомдлын

⁸ 32.1.Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

32.1.1.мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал;

⁹ 34.1.2.оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;

¹⁰ Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

¹¹ 33.2.1.техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;

¹² 33.2.2.техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох.

¹³ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



дагуу нөхцөл байдлыг дахин тодруулахаар гомдол гаргагчид албан бичиг хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй байна.

Бүлэг II. Худалдан авах ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.1. Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг бүрэн тооцсон байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан эсэх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн эсэх, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь бодитой хянаж, баталгаажуулсан эсэх, гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг тооцсон эсэхийг нотлох баримттай тулган шалгалаа.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

Тус газар нь 2018 онд 124.3 сая төгрөгөөр 7, 2019 онд 217.2 сая төгрөгөөр 18 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө баталсан байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд 2018 онд гүйцэтгэлийн аудит хийгдэж худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна гэсэн дүгнэлт өгч зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн тул 2018 оны худалдан авах ажиллагааг үзээгүй болно.

2019 онд төлөвлөсөн 18 ажлаас 3 ажил хийгдэж дууссан байна.

1. “Конторын 1 дүгээр давхар болон шатны хонгилын засвар” ажлыг 60 хоногийн дотор нийлүүлэх 74.6 сая төгрөгийн гэрээг “Талын сүлд” ХХК-тай байгуулж хугацаанд нь комиссын актаар хүлээн авсан байна.

2. “Санхүүгийн программ шинэчлэх” ажлыг 10 хоногийн дотор нийлүүлэх 9.6 сая төгрөгийн гэрээг “Нэхийт софт” ХХК-тай шууд байгуулж хугацаанд нь комиссын актаар хүлээн авсан байна.

3. “Офиссын тавилга, худалдан авах” ажлыг шууд худалдан авалтаар гэрээний хугацаанд комиссын актаар хүлээн авсан байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

2018 онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй, 2019 онд 30.0 сая төгрөгөөр 1 ажил төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/74 тоот “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн дагуу Хэрлэн сумын 5 дугаар багийн “Хур хогийн цэвэрлэгээ, хог зайлуулах ажил”-ыг гүйцэтгэсэн байна.

“Хур хогийн цэвэрлэгээ, хог зайлуулах ажил”-ын багц-1 ковшны дугуй, шүд, соёог 2019 оны 04 дүгээр сарын 20-ны дотор нийлүүлэх 16.0 сая төгрөгийн гэрээг “Мянган ургац” ХХК-тай байгуулсан байна. Ажил хүлээн авах комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж гэрээний хугацаанд нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийн дагуу бүрэн хүлээн авч комиссын хурлын тэмдэглэлээр баталгаажсан байна.

“Хур хогийн цэвэрлэгээ, хог зайлуулах ажил”-ын багц-2 шатахууны 13.3 сая



төгрөгийн гэрээг “Гранд Восток Монголиа” ХХК-тай байгуулж техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийн дагуу бүрэн хүлээн авч комиссын хурлын тэмдэглэлээр баталгаажсан байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

2018 онд 143.0 сая төгрөгийн 4 бараа, ажил, үйлчилгээ, 2019 онд 110.0 сая төгрөгийн 2 бараа, ажил худалдан авахаар гүйцэтгэсэн байна.

1. “Авто замын гэрлэн дохио” шинээр суурилуулах ажлын бараа материал худалдан авах ажлыг 30 хоногийн дотор нийлүүлэх 44.0 сая төгрөгийн гэрээг “Электрон тоног төхөөрөмж” ХХК-тай байгуулж гэрээний хугацаанд комиссын актаар хүлээн авсан байна.

2. “Зуны хүлэмж худалдан авах” ажлыг 60 хоногийн дотор нийлүүлэх 16.0 сая төгрөгийн гэрээг “Электрон тоног төхөөрөмж” ХХК-тай байгуулж хугацаанд нь комиссын актаар хүлээн авсан байна.

3. “Гэрэл сэтгэмж ОНӨААТҮГ-ын машин тоног төхөөрөмж” нийлүүлэх 50.0 сая төгрөгийн гэрээг “Мянган-Ургац” ХХК-тай байгуулж хугацаанд нь хүлээн авсан байна.

4. “Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ хийх” ажлыг 30 хоногийн дотор нийлүүлэх 33.0 сая төгрөгийн гэрээг “Баян луу” ХХК-тай байгуулж хугацаанд нь хүлээн авсан байна.

5. “Гэрэлтүүлгийн материал” худалдан авах ажлыг 70.5 сая төгрөгийн гэрээг “Их говийн тэнгэр групп” ХХК-тай байгуулж хугацаанд нь комиссын актаар хүлээн авсан байна.

6. “Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн” хиймэл нуурын тохижилтын ажил 2019 оны 1 дүгээр улиралд тендер шалгаруулалтын ажил хийгдсэн байна.

“ДБЭХС” ТӨХК:

Тус компани нь жил бүрийн үйл ажиллагаандаа худалдан авах бараа, ажил үйлчилгээг төлөвлөж, ТУЗ-ийн хуралд оруулж, ТӨХ-оор баталсан жилийн зорилтот түвшний үзүүлэлтэд тусгадаг байна.

2018 онд өөрийн хөрөнгөөр ДБЭХС ТӨХК нь Хөрөнгө оруулалтын 29 ажил, их засварын 17 ажил, техник, зохион байгуулалтын арга хэмжээний чиглэлээр 15 ажил, барилгын засварын 6 ажил, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 7 ажил, үйлчилгээний чиглэлээр 3 ажил, бусад худалдан авалтаар 31 ажил, Сүхбаатар салбарт 15 ажил нийт 123 ажил буюу 13.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын худалдан авах арга хэмжээг зохион байгуулж ажиллахаар төлөвлөн батлуулж гүйцэтгэсэн байна.

2018 онд төлөвлөгөөт 123 нэр төрлийн 13.3 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийж гүйцэтгэхээс 122 нэр төрлийн худалдан авалтад 13.0 тэрбум төгрөгийг зарцуулж 0.3 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2018 онд төсөвт өртгөөс хэтэрсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулан дараах ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт №6. /мян..төг/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэтрэлт	
				Зөрүү дүн	Хувиар
1	Шатахуун, дизель түлш, шатах тослох материал	613 444.2	667 775.7	54331.5	8.9
2	Мазут	363 000.0	390000.0	27000.0	7.4
3	Фосфатын дозатор насос	8000.0	10000.0	2000.0	25.0
	Дүн			83331.5	



Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.1-д “дараах тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана”, 30.1.3-т “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн”, 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Худалдах, худалдан авах гэрээг дүгнэж гэрээнд заагдсан хугацааг тухайн компаниас шалтгаалж хэтрүүлсэн 14 ажилд 27.0 сая төгрөгийн алдангийг 2018 онд суутган тооцсон байна. Үүнд:

- “Восток энерго монтаж” ХХК-ийн гүйцэтгэсэн турбины сэлбэг нийлүүлэх ажил 41 хоногоор хугацаа хэтэрсэнд 6.2 сая төгрөгийн алданги,
- “Повертүүл” ХХК-ийн гүйцэтгэсэн ЦДАШ болон дэд станцын материал нийлүүлэх ажил 33 хоногоор хугацаа хэтэрсэнд 4.1 сая төгрөгийн алданги,
- “Их ханас” ХХК-ийн гүйцэтгэсэн төв агуулах болон авто граж, ЦШС цехэд хяналтын камер, дохиоллын систем суурилуулах ажил 9 хоногоор хугацаа хэтэрсэнд 72.7 мянган төгрөгийн алданги,
- “Шелтек Монголиа” ХХК-ийн гүйцэтгэсэн материал нийлүүлэх ажил нийт 5 хоногоор хугацаа хэтэрсэнд 60.0 мянган төгрөгийн алданги,
- “Хэрлэн зураглал” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 5 хоногоор хугацаа хэтэрсэнд 124.8 мянган төгрөгийн алданги,
- “МЭЗ” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 29 хоногоор хугацаа хэтэрсэнд 11.6 сая төгрөгийн алданги,
- “Хишигтпартнерс” ХХК-ийн гүйцэтгэсэн бараа материал нийлүүлэх ажил нийт 20 хоногоор хугацаа хэтэрсэнд 423.7 мянган төгрөгийн алданги,
- “Халиун проперти” ХХК-ийн гүйцэтгэсэн материал нийлүүлэх ажил нийт 96 хоногоор хугацаа хэтэрсэнд 879.1 мянган төгрөгийн алданги,
- “Наран түүчээ” ХХК-ийн гүйцэтгэсэн материал нийлүүлэх ажил нийт 30 хоногоор хугацаа хэтэрсэнд 547.5 мянган төгрөгийн алданги,
- “МЗЭ” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 13 хоногоор хугацаа хэтэрсэнд 801.9 мянган төгрөгийн алданги,
- “Дорнын тэнхлэг” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 7 хоногоор хугацаа хэтэрсэнд 120.0 мянган төгрөгийн алданги,
- “Давст оргил” ХХК-ийн гүйцэтгэсэн техникийн давс нийлүүлэх ажил нийт 24 хоногоор хугацаа хэтэрсэнд 1.1 сая төгрөгийн алданги,
- “Хазаарбат” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 82 хоногоор хугацаа хэтэрсэнд 773.2 мянган төгрөгийн алданги,
- “Талын пирамид” ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажил нийт 1 хоногоор хугацаа хэтэрсэнд 171.7 мянган төгрөгийн алданги.

Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид алданги тооцсон эсэхийг нотлох баримттай тулган үзэхэд бүрэн тооцсон байна.

2.2. Тайлант хугацаан дахь худалдан авалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалттай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит газруудын худалдан авах ажиллагаа тухайн жилд хүрэх зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хөрөнгийн ашиглалт үр дүнтэй эсэхийг газар дээр нь очиж үзлээ.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

2019 онд 217.2 сая төгрөгөөр 18 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө батлагдсанаас 3 ажил гүйцэтгэж дууссан байна.



Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хугацааг тодорхой зааж өгөөгүйтэй холбоотой эхний улирлын байдлаар зорилтот түвшин хэдэн хувьтай хангагдсаныг гаргах боломжгүй байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

2018 онд 143.0 сая төгрөгийн 4 бараа, ажил, үйлчилгээ, 2019 онд 70.5 сая төгрөгийн 2 ажил гүйцэтгэж 1 ажил гүйцэтгэх үе шатанд явагдаж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүйгээс шалтгаалж 2019 оны эхний улирлын зорилтот түвшин бүрэн хангагдсан эсэхийг гаргах боломжгүй байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

Тус газар нь 2018 онд 10.0 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийгдээгүй, 2019 онд 30.0 сая төгрөгөөр 1 ажил төлөвлөж хугацаанд нь хийж дуусгасан байна.

“ДБЭХС” ТӨХК:

2018 онд нийт 123 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 121 ажил хийгдэж гүйцэтгэл 98.4 хувьтай байна.

Эдгээрээс төлөвлөсөн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй дараах ажлууд байна. Үүнд:

Турбины нөөц сэлбэг худалдан авах ажил нь 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт зарлагдсан боловч амжилтгүй болсноос шалтгаалж он дамжин хийгдэхээр гэрээ байгуулагдсан байна.

Зуухны хөөлөлтийн аппарат худалдан авах ажил нь гүйцэтгэгч компани олдохгүйгээс хэрэгжээгүй байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд эхний улирлын байдлаар 3 ажлыг дуусгавар болгож гэрээг дүгнэхээр төлөвлөгдсөнөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 онд нийлүүлэгдсэн хөрөнгийг дээрх байгууллагуудад очиж үзэж, ашиглалтын байдалтай танилцахад хэвийн ажиллагаатай байна.

Дорнод НАА” ОНӨААТҮГ нь “Санхүүгийн программ шинэчлэл” 9.6 сая төгрөгийн ажлыг ашиглаж эхлээгүй байна.

Аудитын хамрах хугацаанд нийлүүлэгдсэн бараа, ажлуудын ашиглалтын талаар санал, гомдол гарч нийлүүлэгч, гүйцэтгэгчтэй харьцсан тохиолдол гараагүй байна.

2.3. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4-д аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж



ажиллана гэж заасан.

Аудитын явцад аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудын дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь 2018 онд бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны хяналт шалгалтыг хийсэн эсэхийг үзлээ.

“ДБЭХС” ТӨХК:

Тус компанийн Дотоод хяналтын алба нь өөрийн хөрөнгөөр 2018 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж ажилласан байна.

Дотоод хяналтын албанаас хяналт шалгалтаар хийсэн ажлын тайланг гүйцэтгэх захиралд танилцуулсан ч тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ:

Тус ОНӨААТҮГ нь өөрийн болон бусад хөрөнгөөр 2018 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах шаардлага гараагүй тул хяналт хийгдээгүй байна.

Харин 2019 оны 1 дүгээр улиралд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаанд тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь хяналт шалгалтыг хийгээгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж байх шаардлагатай байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ:

Тус ОНӨААТҮГ-ын дотоод хяналт шалгалтын ажилтан нь дээрх журмын 3.4-д заасны хяналт шалгалтыг хийхээр төлөвлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж байх шаардлагатай байна.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ:

Тус ОНӨААТҮГ нь 2018, 2019 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна. Харин тус байгууллагын дотоод хяналтын ажилтан нь худалдан авах ажиллагаанд хяналт шалгалтыг хийхээр төлөвлөөгүй байна.

Иймд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж байх шаардлагатай байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ТБОНӨААТҮГ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүй байна.
2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д заасан төлөөллийг бүрэн оролцуулаагүй байна.
3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
4. Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг бүрэн тооцсон байна.
5. Тайлант хугацаан дахь худалдан авалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалттай байна.
6. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд байна.

Аудитаар нийт 6347.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 2367.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага, 3979.4 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч ажиллалаа.



2019.06.25

**Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан
авах ажиллагааны үр дүн**



**"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

21065, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас/Факс: 7058-4545
E-mail: info@ees.energy.mn

2019.06.19 № 1569

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан
шаардлагыг хэрэгжүүлж ажиллах болохыг мэдэгдэж
байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ОТГОНБААТАР

**ДОРНОД АЙМАГ
"ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ"
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

21063, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас/Факс: 7058-4496

2019.06.19 № 391

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТБАЯР ТАНАА**

"Төрийн болон орон нутгийн өмчит
компаниудын Худалдан авах ажиллагааны үр дүн"-
д хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЯРСАЙХАН

Хөтлөх хэрэг 1-8

My doc-2018 blank A5

580619427

260619405



**ДОРНОД АЙМАГ
"ГЭРЭЛСЭТГЭМЖ" ОНӨААТҮГ**

21067, Чойбалсан, Дорнод аймаг,
УБД: 0714001019, Утас: 7058-5811, 99582070

2019.06.19 № 46

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БАТБАЯР ТАНАА**

3368912 регистрийн дугаартай
"Гэрэлсэтгэмж" ОНӨААТҮГ-газрын худалдан авах
ажиллагааны үр дүнгийн шалгалтаар илэрсэн
зөрчлийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА



Б.ГЭРЭЛТ-ОД



**ДОРНОД АЙМАГ
"ЧОЙБАЛСАН ХӨГЖИЛ" ОНӨААТҮГ**

21077, Дорнод аймаг, Хэрлэн сум,
Утас: 7058-2832

2019.06.19 № 94

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТБАЯР ТАНАА**

"Төрийн болон орон нутгийн өмчит
компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн"-д
хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг
үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах болно.

Хүндэтгэсэн

ЗАХИРАЛ



Б.ТЭГШЖАРГАЛ

Хөтлөх хэрэг №2

C:\My Document\Barimtuud\A5

020619032

650619183



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

“ДБЭХС” ТӨХК, “Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал, дарга нарт:

1. Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө үр дүнгийн тооцоо, судалгаанд үндэслэж байх.
2. Үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4-д заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж байх.

“Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын захирал, дарга нарт:

1. Тендерийн үнэлгээний хороонд орсон гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах.

“ДБЭХС” ТӨХК, “Дорнод НАА” ОНӨААТҮГ, “Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нарт:

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллах.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ, “Гэрэл сэтгэмж” ОНӨААТҮГ, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал, дарга нарт:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг журмын дагуу гарган батлуулж байх.
2. Худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж байх, үр дүнг сайжруулах.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд:

1. Ашиглалтгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг сайжруулах.

Аудитаар тавигдсан албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



2019.06.25

**Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан
авах ажиллагааны үр дүн**


ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр Дүрм 21

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудитын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тавигдсан албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Дорнод НАА" ОНӨААТҮГ, Гэрэл сэтгэмж" ОНӨААТҮГ, "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал, дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ц.БАТБАЯР

110419047

Тэргүүлэх аудитын 2019 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

2019.06.25

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн (Тэрбум)
1	"ДБЭХС" ТӨХК	ДОА-2019/40-ГА	Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах тухай	2367,8
2	"Гэрэл сэтгэмж" ОНӨААТҮГ	ДОА-2019/40-ГА		
Нийт дүн				2 367,8



2019.06.25

Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 06 сарын 24 өдөр
Дугуйн №144-А04-2019/40/-ГА
Чойбалсан хот

Г Хууль, журмын хэрэгжилтийг
хангуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар "Гэрэлт сэтгэмж" ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагааг төлөвлөлтгүйгээр хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1 дэх "Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашгийтай, хэмжээтэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хуулийн 48 дугаар зүйл болон энэ журамд заасны дагуу захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д ... албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Дээрх алдааг дахин давтан гаргахгүй байхад анхаарч, хууль, журмуудыг ханган ажиллахыг үүрэг болгож байна.

110019400

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 06 сарын 24 өдөр
Дугуйн №144-А04-2019/40/-ГА
Чойбалсан хот

Г Хууль, журмын хэрэгжилтийг
хангуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар "ДБЭХС" ТӨХК-ийн худалдан авах ажиллагаанд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төлөвлөгөөнд тусгаагүй 192,1 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2. Гэрээ шууд байгуулах босго үнээс давсан 175,7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлалгүй шууд гэрээ байгуулсан байна.
3. Хэрэгцээлэлт, нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон 2,0 тэрбум төгрөгийн 22 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан талаарх үндэслэл, тайланг Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.4 дэх "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирал байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийн хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашгийтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг харьяа дотоод аудитын нэгжээр дамжуулан хянан, батална", 2.9 дэх "Захиалагч тухайн жилд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрджө ажиллах бөгөөд төлөвлөгөөнд тусгаагаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэлийг худалдан авах ажиллагааны тайланд тодорхой тусгана", төсвийн тухай хуулийн 24.4 дэх "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.3 дэх "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно", 33.4 дэх "Хэрэгцээлэлт амжилтгүй болсноос гэрээ байгуулах эрх олгоогүй бол гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болно", 34.3 дэх "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

110019399

Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Гэрэлт сэтгэмж" ОНӨААТҮГ-ын дарга Б.Гэрэлт-Одод даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР
В.ЦЭНГЭЛМАА
АХЛАХ АУДИТОР
Б.ДЭЛГЭРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
"ГЭРЭЛТ СЭТГЭМЖ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ГЭРЭЛТ-ОД

1 Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хуваанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцагаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д ... албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Дээрх алдаа, зөрчлийг даван гаргахгүй байхад анхаарч, хууль, журмуудыг ханган ажиллахыг үүрэг болгож байна.

Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "ДБЭХС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР
В.ЦЭНГЭЛМАА
АУДИТОР
Я.ЗОРИГ

ЗӨВШӨӨРСӨН:
"ДБЭХС" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ОТГОНБААТАР

1 Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хуваанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцагаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.